

ДЭЛГЭРЦОГТ СУМЫН АХМАДЫН ХОРООНЫ
2018 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

2018 оны 06 дугаар сарын 20

Амардалай

Нэг: Ахмад настны талаарх хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилт

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.2 дахь хэсэг, 14.8 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1, 12.5 дахь заалтыг хэрэгжүүлэхээр МАХХ-АШ МАЯГТ №1-ээр бүртгэгдсэн 202 ахмадыг 23 байгууллага, ААН, ТББ, салбарт харъяалуулж, сумын Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 12-ны А/.... тоот захирамжаар баталгаажууллаа.

Ахмадын тухай хуулийн заалтуудыг хэрэгжүүлэхээр Насны хишиг олголтонд хяналт тавьж, ахмадын амралт, рашаан сувилалд амруулан хөнгөлөлт эдлүүлж, харж хандах хүнгүй ганц бие ахмад настнуудыг журмын дагуу түлээний хөнгөлөлтөнд хамруулав.

Суманд “Ёслол хүндэтгэл, ахмадын өргөө” байгуулах асуудлын санхүүгийн эх үүсвэрийг 2017 оны төсвийн тодотголоор сумын Засаг дарга хэлэлцүүлэн 30.0 сая төгрөг батлуулаад байна.

Хоёр: Ахмад настны эрүүл мэндийг сайжруулах талаар

Ахмадуудын эрүүл мэнд, эрүүл насжилт, эрүүл амьдралын хэвшилийн талаарх мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор Ахмадын хорооноос “Хөдөлгөөн - Эрүүл мэнд”, “Ясны шөлний ашиг тус” зэрэг сэдвээр давхардсан тоогоор 31 хүнд, ЭМТ-өөс “Ханиад томууны халдвараас сэргийлэх нь” гэсэн сэдвээр 25 ахмадад сургалт хийсэн байна. ЭМТ-д өдрийн эмчилгээний ороор эмчилгээ сувилгаанд 22 ахмад хамрагдсан. Ахмадын амралт сувилалд өнгөрсөн жил амарсан 1 ахмад, рашаан сувилалд сувилуулсан 2 ахмад хөнгөлөлтөө нөхөн аваад байна. Сумын Эмийн эргэлтийн сангаас ахмадуудад хөнгөлөлттэй эмээр зохих журмаар үйлчилж байна.

Гурав: Ахмад настны нийгмийн хамгаалал, халамж үйлчилгээний талаар

Байнгын асрамжинд байдаг 13 хүнд ах дүү, үр хүүхэд, хөрш, найз нөхөд сайн дурынхан 19 хүн асрамжийн үйлчилгээ үзүүлж байна.

Настангуудын шүд, сонсголын аппарат зэрэг протезийн хэрэглэлийн хөнгөлөлтөд 3 хүн хамрагдаж, 3309.0 мянган төгрөгийн хөнгөлөлт авчээ. Нас барсан 7 ахмад настны ар гэрт НД-ын сангаас 7000.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон. Рашаан сувилалын хөнгөлөлт 2 хүнд 174.0 төгрөг олгогджээ.

Шинэ хуулиар олгогдож эхэлсэн “Насны хишиг”-т Цагаан сараар 104 хүн хамрагдаж, 10410.0 мянгантөгрөг авчээ. Нас барсан 3 хүнд 3.0 сая төгрөгийн тэтгэмж, арг гэрт нь олгожээ.

Дөрөв: Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх талаар

Сургуулийн эмчийн орон тоонд ахмад эмч, англи хэлний багш, хими биологийн багшаар 2 ахмад багш тус тус гэрээгээр ба цагаар ажиллаж байна.

Тав: Тэмдэглэлт өдрүүдээр хүндэтгэл үзүүлсэн байдал

Сумын Засаг даргын Захирамжаар нийт 204 ахмадуудыг, 23 байгууллага, аж ахуйн нэгжид харъяалуулсан. Цагаан сараар бүртгэлтэй 23 байгууллага, аж ахуйн нэгжээс 15 нь 147 ахмадад 2755.8 мянган төгрөгийн хүндэтгэл үзүүлсэн байна. Аж ахуйн нэгжүүд “Ахмадын сан” -гүй гэдэг шалтгаанаар харъяаллын ахмадууддаа хүндэтгэл үзүүлж чадахгүй байх, зарим байгууллагууд зөвхөн сумын төв дээр байгаа ахмадуудад хүндэтгэл үзүүлэх зэрэг бэрхшээл байсаар байна.

Эхний 3 сарын байплаар аймаг сумын ЗД-ын шагналаар 6 ахмад, Яам, ЗГ-ын шагналаар 3 ахмад настан, төрийн одон медалиар 1 ахмад шагнуулж, 1 ахмад аймгийн аварга малчин цол хүртлээ. 4-5 ахмад ТББ, намуудын шагналаар шагнуулсан байна.

Зургаа: Ахмадын авъяас, чадвар, ёс заншлыг өвүүлэх талаар

Төрийн байгууллагууд бүгд ахмад үеийнхнээ судлан, үе үеийн удирдлага, алдартнуудаа сурталчлан алдаршуулах ажлыг эхлүүлээд байна.

Сумын ахмадуудын анхдугаар чуулганаас цагаан сар, баяр наадам, бусад тэмдэглэлт өдрүүд, баяр наадмаар архины хэрэглээг хязгаарлаж, зөв зохистой цэнгэн наадах талаар нийт иргэдэд хандсан “Уриалга” гарган сумын удирдлагуудад гардуулснаа Цагаан сарын баярыг угтан залуус, нийт иргэдэд сурталчлан хүргэлээ.

Долоо: Ахмадын байгууллага, ахмад настны талаарх сурталчилгаа, мэдээ, мэдээлэл

Ахмадын хорооноос зохион байгуулж байгаа ажил, хийгдэх ажлын талаархи мэдээллийн нийгмийн сүлжээний Нүүр номын хуудсаар тогтмол мэдээлж байна. Багуудын ахмадын Зөвлөл, багийн Засаг дарга нартай хамтран сумын ахмадуудын судалгааг шинэчилсэн маягтын дагуу хийж, холбогдох халамж үйлчилгээнд хамруулах ажлыг гүйцэтгэж байна. Энэ судалгааг МАхХ – АШ маягт №1-ээр хийж нэгтгэлээ.

Мөн ахмадуудын авсан шагнал урамшлын нэгтсэн судалгаа сантай болж байна. Ингэснээр тэднийг алдаршуулах, дараагийн шатны шагналд хамруулах судалгаатай болж байна.

Найм: Ахмадын хорооны санхүүжилтийг нэмэгдүүлэх талаар

Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор батлагдсан журмуудыг байгууллага, ААН-ийн дарга эрхлэгч нарт “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ыг гарын авлагаар бэлтгэн хүргэлээ. Оны эцсийн тооцоо тайлангаа үндэслэн төрийн байгууллагууд боломжоороо “Ахмадын сан” байгуулан, харъяаллын ахмадууддаа хүндэтгэл үзүүлээд байна.

